



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 314

Улаанбаатар хот

“Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм”-д доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалтыг нэмсүгэй:

1. Нэгдүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг:

“1.3. ”Холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Хорооны шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад тавих хяналт шалгалтыг улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч хэрэгжүүлнэ.”

2. Тавдугаар зүйлийн 5.1,5.2 дахь хэсэг:

“5.1. Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “..ахлах байцаагч” гэсний дараа “холбогдох газрын дарга, орлогч дарга, хэлтсийн дарга, хянан шалгагч нь улсын байцаагч байна.

5.2. Улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Улсын ерөнхий байцаагч олгоно”.

Хоёр. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрмийн “Арван тав” дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчилөн найруулсугай:

1. “Арван тав. Бусад зүйл

15.1. Улсын байцаагчийн шийтгэвэр, албан шаардлагыг Хамаарах этгээд, албан тушаалтан тогтоосон хугацаанд биелүүлж, хариуг албан ёсоор мэдэгдэнэ.

15.2. Улсын байцаагчийн гаргасан шийтгэврийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо шийтгэвэр гарснаас хойш 10 хоногийн дотор улсын ахлах байцаагчид, улсын ахлах байцаагчийн шийтгэвэрт улсын ерөнхий байцаагчид гаргаж болно.

15.3. Улсын байцаагчийн шийтгэврийг үндэслэлгүй гэж үзвэл улсын ахлах байцаагч; улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн шийтгэврийг үндэслэлгүй гэж үзвэл улсын ерөнхий байцаагч уг шийтгэврийг өөрчлөх буюу хүчингүй болгож болно.

000923


15.4. Улсын байцаагч үүрэгт ажлаа хуулийн дагуу зохих ёсоор биелүүлээгүй бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Гурав. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрмийн Тавдугаар зүйлийн “5.2,5.3,5.4” дэх хэсгийн дугаарыг “5.3,5.4,5.5” гэж, Есдүгээр зүйлийн “9.1.10,9.1.11” гэснийг “9.1.9,9.1.10” гэж тус тус өөрчилсүгэй.

Дөрөв. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтын “Хамаарах этгээдийг Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх удирдлага, тэдгээртэй адилтгах зөвлөлийн гишүүн байх” гэснийг хассугай.

Тав. “Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 154 дүгээр тогтоолоор батлагдсан Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэмд нэмэлт, өөрчлөлтийг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА